



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ!

№104 /104/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.03

ҮЙЛ ЯВДАЛ

НУБ-ЫН ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕРЫН ДАМЖАА ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв 2021 оны 8 дугаар сарын 2-20-ны өдрүүдэд НУБ-ын Цэргийн ажиглагч офицерын дамжааг бие даан англи хэлээр НУБ-ын сургалтын стандарт, хөтөлбөрт нийцүүлэн зохион байгуулж байна.

Тус дамжаанд Зэвсэгт хүчний 22 анги, байгууллагын 32 цэргийн алба хаагч суралцаж байгаа бөгөөд Нэгдсэн Үндэстний суурин зохицуулагчийн газар, Монголын Улаан

загалмайн нийгэмлэг, Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллаж мэргэжлийн болон ажиллагааны туршлага сургажигчид үндэслэн зочин багш нарыг урин тухайлсан хичээлийг заалган сургалтыг явуулж байгаа юм.

Дамжааны сургалт нийт 3 долоо хоногийн хугацаанд явагдах бөгөөд онолын болон дадлагын хичээл хосолмол байдлаар явагдана. Цар тахлаас шалтгаалан дамжааг зөвхөн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчидтай

явуулж байгаа бөгөөд Улсын онцгой комиссоос гаргасан зөвлөмж, зааврыг чанд сахин мөрдөж, халдвараас урьдчилан сэргийлж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалын харьяа Дэлхийн энхийн ажиллагааны санаачилга байгууллагатай хамтран 2009 оноос эхлэн уг дамжааг зохион байгуулж байгаа бөгөөд 2019 оноос эхлэн бие даан зохион байгуулж байгаа юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	☁️ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	☁️ 21

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	☁️ 19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.0	2.851.0
EUR 🇪🇺	3.38.0	3.390.0
CNY 🇨🇳	441.0	442.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.70	26.24
KRW 🇰🇷	2.43	2.52

ЗУРХАЙ

2021.08.03 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 25/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ЕСӨН УЛААН ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

05:31-20:25

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

Хий

Өдрийн наран 5 цаг 31 минутад мандан, 20 цаг 25 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээр сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал худалдан авах, мал түгээх, сахил санаар авах, хануур, төөнүүр хийлгэх, хийморийн дарцаг хатгахад сайн. Эрдэнийг гадагш өгөх, уул овоо тахиад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Хүүхдийн сэллэг үргээлгэх буюу үс засуулахад тохиромжгүй бөгөөд нүд бүрэлзэн улцайна хэмээжээ.

Ахлах дэслэгч Д.ЭРДЭНЭСУВД

АНУ-ЫН ТӨВИЙН КОМАНДАГЧААС ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГТ ЗАХИДАЛ ИРҮҮЛЖЭЭ

Эрхэм дэслэгч генерал аа, АНУ-ын Төвийн командлалд алба хааж буй нийт бие бүрэлдэхүүнийхээ нэрийн өмнөөс Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд сүүлийн 18 жилийн хугацаанд Афганистан Улсад явагдсан цэргийн ажиллагаанд бидэнтэй хамтран үүрэг гүйцэтгэсэнд талархаж байгаагаа илэрхийлье.

АНУ-ын Төвийн командлалын хариуцлагын бүс нутагт явуулж буй энх тайван, аюулгүй байдлыг сахиулах их үйл хэрэгт Монгол Улс хамтран үүрэг гүйцэтгэж, асар их хувь нэмэр оруулсан бидний найдвартай түнш улс юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчний 600 гаруй цэргийн алба хаагч Афганистан Улсад цөөнгүй төрлийн үүргийг гүйцэтгэсэн бөгөөд тэдгээрээс Файзабад дахь бие бүрэлдэхүүний хамгаалалт, Эггерс дэх баазын хамгаалалт,

Кабул дахь олон улсын нисэх буудлын хамгаалалтын үүргийг маш сайн гүйцэтгэснийг онцгойлон дурдахад таатай байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Афганистаны Үндэсний Батлан хамгаалах, аюулгүй байдлын хүчний бие бүрэлдэхүүнийг сургах, зөвлөх, дэмжлэг үзүүлэх үүргийг амжилттай гүйцэтгэлээ. Эрхэм генерал танд эрүүл энх,



сайн сайхан бүхнийг хүсье.

Таны Афганистан Улсад аюулгүй байдлыг сахиулах их үйл хэрэгт оруулсан хувь нэмэр, дэмжлэгт дахин талархлаа илэрхийлье.

Таныг хүндэтгэсэн командлагч, Тэнгисийн явган цэргийн генерал Кеннет Миккензи.

ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨРТ



Зэвсэгт хүчний 337 дугаар анги

Ангийн Эрүүл мэндийн төв, "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-тэй хамтран 2021 оны 7 дугаар сарын 27 буюу "Цусны донорын дэлхийн өдөр" цус хандивлах аянд офицер, ахлагч, ажилтан албан хаагчид цар тахлын үеийн халдвар хамгааллын дэглэмийг баримтлан идэвхтэй оролцлоо. Энэ үеэр "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-өөс ангийн бие бүрэлдэхүүнд цусаа өгөхийн ач холбогдлын талаар мэдээлэл өгсөн юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 165.147 +992	ЭДГЭРСЭН 143.803 +2058	НАС БАРСАН 820 +5
----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4123 +74	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 248 +64	ЭДГЭРСЭН 3798 +64
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 198,973,312
Эдгэрсэн Нийт: 179,595,844
Нас барсан Нийт: 4,239,692



СПОРТ



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам энэ сарын 23-нд эхэлээд байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

ӨНӨӨДӨР С. БАТЦЭЦЭГ, Х.БОЛОРТУЯА НАР ОЛИМПЫН ДЭВЖЭЭНД ХҮЧЭЭ СОРИНО



Өнөөдөр "Токио-2020" Зуны олимпын XXXII наадмын чөлөөт бөхийн 2 эмэгтэй тамирчин Монгол Улсаа төлөөлж олимпын дэвжээнд хүч, ур чадвараа сорин барилдана. Тухайлбал, эмэгтэйчүүдийн 62 кг-д ОУХМ Хүрэлхүүгийн Болортуяа эхний даваанд Энэтхэгийн залуу бөх Сонам Маликтай барилдах сугалаатай. Түүнийг давбал шөвгийн наймд Бразилын Лаис Нунес, Болгарын бөх, дэлхийн аварга, дэлхийн дэвжээнээс нийт 6 медаль хүртсэн Тайбе Юсеин нарын

ялсантай халз барилдах оноолттой. Х.Болортуяагийн хувьд 2020 оны Иван Ярыгиний Гран прид түрүүлж, Ази тивийн аваргад үзүүлсэн амжилттайгаар Токиогийн олимпод хүчээ сорихоор ирээд байгаа юм. Урьдчилсан шатны барилдаан Улаанбаатарын цагаар 11:00 цагт эхлэх бөгөөд манай тамирчин 7 дахь барилдаанд дэвжээнд гарна. Энэ өдөр "Лондон-2012" олимпын наадмын хүрэл медальт, дэлхийн хошой аварга, Хөдөлмөрийн баатар

С.Батцэцэг Токиогийн олимпын хүрэл медалийн төлөө хүч үзнэ. Өнөөдөр халз тулах Азербайжаны бөх Э.Манолова /ДАШТ-ий хүрэл медальт/, Киргизийн бөх М.Жуманазарова /Азийн наадмын мөнгөн медальт/ нарын хэн ялсан нь манай гавьяат тамирчин С.Батцэцэгтэй медалийн төлөө барилдах юм. Олимпын медалийн төлөөх барилдаанууд 17:15 цагаас эхлэх бөгөөд манай хүн 13 дахь барилдаанд дэвжээнд гарах болно.

ЦОЛ БҮХЭН САЙХАН



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Тус нэгтгэлд алба хааж буй хошууч цолтой бүрэлдэхүүний санаачилгаар 10 километрийн маршийг "Цол бүхэн сайхан" уриан дор Цэцээ гүний ноён оргил руу зохион байгуулж явууллаа.

Арга хэмжээний хүрээнд олс таталт, хөгжөөнт буухиа, "Би бүжиглэх дуртай" зэрэг тэмцээнийг зохион байгуулж нэг өдрийг цэвэр агаарт өнгөрөөж бие бүрэлдэхүүнийхээ дархлааг дэмжлээ.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

СҮҮЛИЙН ДӨРВӨН 7 ХОНОГТ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ 80 ХУВИАР ӨСӨВ



Дэлхий даяар цар тахлын халдварын тархалт өнгөрсөн дөрвөн 7 хоногийн хугацаанд 80 хувиар буюу хоёр дахин нэмэгдлээ гэж ДЭМБ-аас мэдээллээ.

Энэтхэгт анх бүртгэгдсэн корона вирусийн "дельта" хувилбарын халдвар эрчимтэй тархаж, дэлхий даяар дахиад шинэ хувилбарууд гарахаас өмнө вакцинаа хурдан хий

гэсэн дохио өгч байна гэж ДЭМБ-ын ерөнхий захирал анхааруулжээ.

Мөн "Одоогоор Европын холбооны зарим оронд хөгжиж байгаа улс орнуудад корона вирусийн вакцин хандивлахаа амласан ч чинээлэг орнуудад хандсан вакцинтай холбоотой шүүмжлэл нэмэгдсээр байна. Африкийн улсууд дэлхийн хөгжингүй улсууд вакцины талаар маш хангалтгүй ажиллаж байна" гэж шүүмжилжээ.

Өнөөдрийн байдлаар Африк тивийн орнуудын 70 хувь нь энэ оны 9 дүгээр сарын сүүлч гэхэд хүн амынхаа 10 хувийг ч дархлаажуулж чадахааргүй байна. Африкийн орнууд вакцинжуулах аянд бэлтгэж байгаа хэдий ч вакцины нийлүүлэлт ирэхгүй байна гэж ДЭМБ-ын тэргүүн мэдэгджээ.

ГҮЙЛТИЙН ЦАНЫН 2021 ОНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДРОВ



Гүйлтийн цанын 2021 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн нь өнгөрсөн 7 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Скай Ресорт цанын баазын талбайд зохион байгуулагдав. Тэмцээнд Нийслэл, хөдөө орон нутгийн спорт хороодын спорт клубдын 7 багийн 30 гаруй тамирчин эрэгтэй 10,15 км-т, эмэгтэй 5,10 км-т тус тус тэших техникээр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тус тэмцээнд "Алдар" спорт хорооны өвлийн спортын албаны ахлах дасгалжуулагч, хошууч Х.Хаш-Эрдэнээр ахлуулсан 6


тамирчин /эрэгтэй 3, эмэгтэй 3/ оролцсоноос эрэгтэйчүүдийн төрөлд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн дэд ахлагч О.Гантулга хүрэл, "Алдар" спорт хорооны дэд ахлагч Д.Мөнхгэрэл, Д.Золбаяр нар дөрөв, тавдугаар байруудыг эзэлсэн бол эмэгтэйчүүдийн төрөлд Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн дэд ахлагч Э.Ариунтунгалаг алт, "Алдар" спорт хорооны тамирчин, дэд ахлагч А.Энхтуул мөнгөн медаль хүртэж, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн дэд ахлагч Э.Ариунзүл 7 дугаар байр тус тус эзэллээ.

ЭНЭ САРД ХУР ТУНАДАС ИХ ОРЖ, ЦОЧИР ХҮЙТЭРЧ БОЛЗОШГҮЙ

Наймдугаар сард төвийн бүс нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй байна. Иймд иргэд болзошгүй үер усны аюулаас болгоомжтой байхыг анхаарууллаа. Харин нутгийн баруун хэсгээр агаарын температур олон жилийн дунджаас дулаан, хур тунадас бага төлөвтэй байгаа нь тухайн бүс нутгаар хуурай гандуу байх нөхцөл бүрдэж болзошгүй.

Сарын нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёр болон гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар дуу цахилгаантай бороо орно. Борооны өмнө салхи түр зуур ширүүсэж 14-16 метр секунд хүрэх, зарим үед 18-20 метр секунд хүрч ширүүсэх төлөвтэй байна.

Мөн гуравдугаар арав хоногийн эхээр баруун болон төвийн бүс нутгаар, сүүлчээр төв болон зүүн зүгийн нутгаар



сэрүүсэж, хөрсөн дээр цочир хүйтрэл ажиглагдаж болзошгүй ЦУОШГ-аас анхаарууллаа.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)